



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ




World Health
Organization
Representative Office
for Mongolia

Ижил мэргэжилтний үнэлгээ

УХТЭ ЭМТҮЧАБА
2023 он

Ижил мэргэжилтний
үнэлгээ гэж юу вэ





Most scientists regarded the new streamlined peer-review process as 'quite an improvement.'

Peer review

Эрүүл мэндийн
тусламжийг
чанартай үзүүлж буй
эсэхийг үнэлэх арга

Чанар сайжруулах
аргын нэг юм

Ижил мэргэжилтний үнэлгээ гэж юу вэ

Мэргэжилтэн, эсвэл баг, багийн гишүүд болон хувь хүний ажлын гүйцэтгэлд үнэлгээ хийхийг ижил мэргэжилтний үнэлгээ гэнэ.

ИМУ гэдэг нь эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, тухайн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хамт олны ажилтай уялдуулан бусаддаа үйл ажиллагаагаа танилцуулах, тасралтгүй боловсрол олгох, ажилтан, хамт олны хариуцлагыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох чанар сайжруулах гол аргын нэг мөн.

Ижил мэргэжилтний үнэлгээ




ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Ижил мэргэжилтний үнэлгээ

- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах
- Чанартай тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах
- Эмчийн алдааг багасгах

- Айдас, шүүмжлэх дургүй
- Ашиг сонирхлын зөрчил
- Ачаалал нэмэгдэх



Ижил мэргэжилтний үнэлгээ

- ✓ Тухайн мэргэжлийн ижил мэргэжилтэн нь хийх нь чухал
- ✓ Эмнэлэг өөрөө зохицуулсан журамтай байх (Эмч нар, сувилагч нар, бусад ажилтнууд хэрхэн хийх, хэзээ нэгтгэн дүгнэх, хэрхэн сайжруулах гэх мэтийг тусгах)
- ✓ Эмнэлгийн бүх тасаг нэгжид, бүх үйл ажиллагаа бүрт
- ✓ Хяналтын хуудсаар, баталсан байх (200 гаруй)
- ✓ Ижил төстэй эмнэлгүүд хоорондоо хийж болно
- ✓ Үнэлгээ хийж буй ажилтны ёс зүй, харилцаа хандлага

Ижил мэргэжилтний үнэлгээ

- ✓ Таны хэрэгжүүлэх үйлчилгээний чанарын тусгал болдог
- ✓ Боловсролын үйл явц байдаг
- ✓ Ижил төстэй туршлага, үүрэг хариуцлага бүхий ажилтнуудын ажиглалтад тулгуурлана
- ✓ Таны өдөр тутмын үйл ажиллагааны загвар болно
- ✓ Таны гүйцэтгэлийн хэмжилт нь дараа нь амьдралд хэрэгжүүлэх стандартууд болно.
- ✓ Эн тэргүүнд сайжруулах шаардлагатай асуудлыг тодорхойлох загвар болно
- ✓ Мэргэжлийн ур чадварыг сайжруулах стратеги төлөвлөлтийн нэн чухал үе шат болдог

Ижил мэргэжилтний үнэлгээ хийх баримт бичиг

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 12 сарын 12-ны
өдрийн 4156 дугаар тушаалын
дөрөвдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ИЖИЛ МЭРГЭЖИЛТНИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн ажилтны үйл ажиллагааны гүйцэтгэлд ижил мэргэжилтний үнэлгээг (цаашид ИМУ гэх) ашиглана.

1.2. Ижил мэргэжилтний үнэлгээ гэдэг нь эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, тухайн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хамт олны ажилтай уялдуулан бусаддаа үйл ажиллагаагаа танилцуулах, тасралтгүй боловсрол олгох, ажилтан, хамт олны хариуцлагыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, чанар сайжруулах гол аргын нэг мөн.

Дөрөвдүгээр хавсралт:

- Эрүүл мэндийн бүх байгууллага
- Байгууллагын бүх ажилтнууд
- Үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах, нууцыг чанд сахих
- Тогтмол, хуваарийн дагуу

Ижил мэргэжилтний үнэлгээ

- Тохиолдолд суурилсан үнэлгээ
 - Гомдол гарах, тохиодол гарах, үл тохирол илрэх,
- Шалгуурт суурилсан үнэлгээ
 - Тусламж үйлчилгээний чанарыг тодорхойлох
 - Шинэ стандарт, удирдамжийн хэрэгжилтийг хянах



Ижил мэргэжилтний үнэлгээний зарчим



- Зөвлөлдөх
- Үнэн, зөв мэдээлэх
- Багаар ажиллах
- Асуудлыг шийдвэрлэх
- Харилцан хүндэтгэлтэй хандах
- Гүйцэтгэл бодитой байх

Үнэлгээний чиглэл

- ЭМС-ын баталсан эмнэл зүйн удирдамж, заавар
- ЭМДҮЗ-ын баталсан нэхэмжлэлийн хяналтын шалгуур
- Эмчилгээ оношилгооны түгээмэл үйлдлийн ба бусад стандартууд
- ЭМБ-ын даргын баталсан эмнэл зүйн заавар
- Үйл ажиллагааны журам
- Ажлын байрны тодорхойлолтонд заагдсан ажил үүрэг

Үнэлгээний хэлбэр

1. Гүйцэтгэсэн үйл ажиллагааг үнэлэх
2. Үйл ажиллагааны тухайн агшинд үнэлэх

Эмнэлгийн мэргэжилтэн:

Үнэлэгч → Тасгийн эрхлэгч → Чанарын менежер,
алба

Эмнэлгийн бус мэргэжилтэн:

Үнэлэгч → Тасгийн эрхлэгч → Хүний нөөцийн алба

ИМУ-ний аргачлал

- Тасаг нэгжийн чанарын баг дотоод хяналтын чиглэл, давтамж, хуваарийг гаргаж ЭМТҮЧАБА-аар батлуулна.
- Ажилтан бүр үнэлгээ хийгч, үнэлэгч болж хамрагдана.
- Батлагдсан хяналтын хуудсыг ашиглана.
 - ЭМС-ын баталсан эмнэл зүйн зааврын дагуу гаргасан хяналтын хуудас
 - ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоол
 - ЭМБ-ийн баталсан заавар, удирдамжийн хяналтын хуудас
- Тасгийн чанарын багийн ахлагч дүгнэлтийг ЭМТҮЧАБА-д өгнө.
- Хэрэгжүүлсэн ажлын тайлан, үр дүнг ЭМТҮЧАБА-д өгнө.



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



World Health Organization
Representative Office
for Mongolia

MNS 4621-2008 ын дагуу боловсруулсан

Шалгуур хуудас: Нярайн ходоодонд хаймсуур тавьж, хооллох

2014 оны 03 сарын 7 өдөр

Тасгийн нэр

№	Шалгуулагчийн нэрс	Монгол	Сейма	Фигурин	Соронзон	Хиймэл	Тогтвор	Монгол	Фигурин	Соронзон	Хиймэл	Тогтвор	Нийт дүн %
1	Сувилагчийн хувийн бэлтгэл: Малгай, үсний хавчаар, эзмэг, бөгж, хумс, энгэрийн тэмдэг, халад, өмд, цамц, гутал	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
I. Харилцааны үр чадвар													
2	Өөрийгөө танилцуулсан эсэх	+	-	-	-	-	-	-	-	-	-	-	0%
3	Эмчлүүлэгчийн асран хамгаалагчтай мэдэлсэн эсэх	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0%
4	Эмчлүүлэгчид хийх үйлдлийн зорилгыг эхэд тайлбарлах	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0%
5	Эмчилгээний заалтыг эмчилгээний хуудас, өвчтөний овог нэртэй тулгаж шалгасан эсэх	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
6	Үйлдлийн явцад болон төгсгөлд эхтэй харилцсан эсэх	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0%
II. Гардан үйлдэл гүйцэтгэх үр чадвар													
7	Хэрэглэгдэх зүйл: ариун бээлий	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0%
8	Хаймсуур № 5-6, №8	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
9	Хуваарь бүхий ариун тариур 5-10 мл	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
10	Ариун ус	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0%
11	Шархны наалт	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
12	Хайч	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
13	чагнуур	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0%
14	Хөхний сүү, шингэн (хооллох)	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
15	Бөөр хэлбэрийн сав	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
16	Гарт байгаа бөгж, цагаа авсан	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
17	Гараа зааврын дагуу угаасан	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
18	Гараа зааврын дагуу халдваргүйжүүлсэн	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
19	Ариун бээлийг зааврын дагуу өмссөн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0%
20	Хүүхдийг зөв байрлуулах	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
21	Ариун хаймсуурыг хамрын угалзнаас чихний омог хүргэн доош явуулж аймхай мөгөөрс хүртэл хэмжиж тэмдэглэх	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
22	Хаймсуурын үзүүрийг ариун усаар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0%

Дотоод хяналт.

Эрхлэлт үйлдлийн
таацарт

хуудас-12
ажилтан-117
эрхлэлтийн % - 94%

79

3	Эзмэг, бөгж	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
4	У	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
ЭХЭМҮТ, Сувилахуйн алба "Шалгуур хуудасны эм"													
23	Хаймсуурыг оруулах үйлдлийг зөв хийсэн эсэх	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
24	Хаймсуур ходоодонд орсон эсэхийг шалгаж буй байдал	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
25	Хаймсуурын үзүүрт тариурыг угсран ходоодны агууламжийг соруулсан эсэх	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
26	Тариурт 2 мл хий соруулж, ходоодны хаймсуураар шахах явцдаа ходоодон дээр чагнуур байрлуулан сонсох	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
27	Ходоодонд зөв байрласан үед хаймсуурыг бэхлэх	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
28	Сүүг тариурт соруулан хаймсуурын үзүүрт бэхлэн, тариурын арын хэсгийг сугалан авч тариурыг дээш өргөн урсгаж хооллох	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
29	Тариур дахь сүү дууссан үед хаймсуурыг тагаар нь бөглөх	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
30	Хийсэн ажилбарва тэмдэглэнэ	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
III. Шалгуулагчийн мэдсэн байх зүйл													
31	Зорилго	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
32	Заалт	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
33	Эсрэг заалт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0%
34	Нярайг хооллох бусад аргуудын тухай	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
35	Анхаарах зүйл	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
36	Хүндрэл	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	100%
Нийт оноо - 36													
Дүнг хүлээн зөвшөөрсөн шалгуулагч													
Хяналт хийсэн: Монгол Улсын /албан тушаал, нэр/ Сүхбаатар													

ИМУ-ний ач холбогдол

Зорилго	Ач холбогдол
Тухайн мэргэжлийн хүрээнд зохицуулалт хийх	Мэргэжлийн чадварыг үнэлдэг Ажилтны гүйцэтгэлийн талаар эргэн мэдээлдэг Алдаагаа хүлээх аюулгүй нөхцөл бүрдүүлдэг
Тасралтгүй боловсрол	Ажилтнуудад хүчтэй талаа тодорхойлох боломж олгодог Мөн сайжруулах шаардлагатай чиглэлийг тодорхойлдог
Шаардлагыг ухамсарлах	Мэдээлэл солилцоо, чанарыг дэмждэг Үйлчлүүлэгч төвтэй мэргэжлийн аргачлалаар асуудлыг шийдвэрлэдэг Мэдээллийг зохион байгуулахад тусладаг
Ажилтан, хамт олны хариуцлага	Ажилтны болон хамт олны чадамж, үйл ажиллагааг сайжруулах баталгаа болдог Эрсдэл, зөрөлдөөн болон үүргийг шилжүүлэх үеэр дэмжлэг болдог
Багийн ажлын сайжруулалт	Багийн гишүүдийг өөр өөрийн онцлогтой, үнэ цэнэтэй хүний нөөц гэж үздэг Тэгш оролцооны мэдрэмж төрүүлдэг Хувь хүний ачаалал дарамтыг хөнгөлдөг

Ижил мэргэжилтний үнэлгээ

Бэлтгэл ажил

- Үзлэгт оролцох эмч, ажилтныг сонгон тэдэнд үзлэг явуулах арга, анхаарах асуудал зэргийг тодорхой тайлбарлаж өгөх.
- Үзлэгээр илэрсэн дутагдлыг тухайн шалгуулж байгаа эмч, ажилтнаас өөр хүмүүст мэдээлэхгүй болохыг ойлгуулах
- Дутагдлыг таслан зогсоох талаар шалгуулж буй эмч, ажилтантай сайн ярилцаж шийдвэрлэх арга замыг хамтран олгох
- Тухайн дутагдал гарахад тогтолцооны ямар алдаа байгаад онцгой анхаарал хандуулах

Ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулахад анхаарах асуудлууд

1. Шалгалтын явцад ажилтны нэр цохож, ажлын доголдлын талаар ярих ёсгүй.
2. Үзлэгээр илэрсэн доголдлыг зөвхөн шалгасан, шалгуулсан хүмүүсийн хүрээнд шүүн ярилцана.
3. Энэхүү үзлэгийн дүнг ажилтнуудын ажлыг дүгнэх, цалин хөлсийг нэмэх, бууруулах, шагнаж урамшуулах зэрэгт харгалзан үзэж болохгүй.





ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



World Health
Organization
Representative Office
for Mongolia

АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА